



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (487)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Замын хөдөлгөөны аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны гуравдугаар сарын 8

№10 (487)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

151.	Жамъяншаравын Дүгэрт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай	Дугаар 23	234
152.	Лэгдэнгийн Дамдинжавт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 24	234
153.	Дамдинсүрэнгийн Цэндэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 25	234
154.	Зандангийн Энэбишид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 26	234
155.	Лувсанчимэдийн Сосрбарамд Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 27	235
156.	Охины Гонсонд Монгол Улсын байгаль орчны гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 28	235
157.	Чагнаагийн Маамууд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 29	235
158.	Очиртовуугийн Соёлтод Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 30	235
159.	Хоохногийн Магсарт Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай	Дугаар 31	236
160.	Жамцын Хишигсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 32	236
161.	Даваажавын Лхагвадолгорт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 33	236
162.	Гончигийн Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 34	236
163.	Дэчинсандуйн Надмидад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 35	237
164.	Загдын Түмэнжаргалд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 36	237

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

165.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай	Дугаар 315	237
------	--	------------	-----

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

166.	Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 0 сая төгрөг хуваарилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 02	251
------	---	-----------	-----



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Жамъяншаравын Дүгэрт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Хүүхэд, залуучуудын болон боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн материаллаг баазыг бэхжүүлэн хүүхдийн сурч, хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлж, хүүхэд, залуучуудыг мэргэжил, боловсролтой иргэн болгон

хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн захирал Жамъяншаравын Дүгэрт Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Лэгдэнгийн Дамдинжавт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай

Автотээвэр, харилцаа холбооны салбар болон төрийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж тээврийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалтыг сайжруулан материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг оновчтой зохион байгуулж, тээврийн салбарыг хөгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг үнэлж төр засгийн ахмад зүтгэлтэн Лэгдэнгийн Дамдинжавт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Дамдинсүрэнгийн Цэндэд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсрол, эрдэм шинжилгээний салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, их, дээд болон дунд сургуулийн оюутан, сурагчид уран зохиолын багш нарт зориулсан сургалт, эрдэм шинжилгээний олон ном, бүтээл туурвиж, боловсролын салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, Монголын уран зохиол, олон улсын Монгол судлалд оруулсан хувь нэмрийг үнэлж Монгол Улсын Боловсролын

их сургуулийн Монгол судлалын сургуулийн утга зохиолын тэнхимийн тэргүүлэх профессор Дамдинсүрэнгийн Цэндэд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Зандангийн Энэбишид Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, сургалт, эрдэм шинжилгээний олон ном, сурэх бичиг туурвиж, химийн шинжлэх ухааны мэргэжилтэй боловсон хүчин, эрдэмтдийг бэлтгэх, боловсролын салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж ахмад

багш Зандангийн Энэбишид Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Лувсанчимэдийн Сосорбарамд Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Биеийн тамир спорт, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж оюутан залуучуудыг үндэсний болон чөлөөт, самбо, жу-до бөхийн барилдааны төрлөөр дасгалжуулан тив дэлхий, олимп, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай бэлтгэн оролцуулж, олон шилдэг тамирчин төрүүлсэн хувь

нэмрийг нь үнэлж ХААИС-ийн багш Лувсанчимэдийн Сосорбарамд Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Охины Гонсонд Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээх тухай

Байгаль орчны болон төрийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагч, улсын байцаагчдыг бэлтгэх, байгаль орчны хяналтыг сайжруулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль

орчны хяналтын улсын ахлах байцаагч Охины Гонсонд Монгол Улсын байгаль орчны гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Чагнаагийн Маамууд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Ой модны аж үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсад анхны орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий импортыг орлох мебелийн үйлдвэр, хоёрдогч түүхий эдийг ашиглан шахмал түлшний үйлдвэр байгуулж, ажлын байр бий болгон, үндэсний үйлдвэрлэлийг

хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Нийслэлийн "Вүүдмэн" ХХК-ийн захирал Чагнаагийн Маамууд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Очиртовуугийн Соёлтод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл, урлаг болон телевизийн байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж олон арван шинэ нийтлэл, нэвтрүүлгүүдийг найруулж үзэгч олны хүртээл болгон, телевизийн олон ангит кино, жүжгийн эхлэлийг тавьж, залуу уран бүтээлчдийг бэлтгэхэд

орүүлж байгаа хувь нэмрийг үнэлж TV-9 телевизийн ерөнхий найруулагч Очиртовуугийн Соёлтод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Хоохногийн Магсарт Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай

Мал сүргээ олон жил тогтвортой өсгөн үржүүлж, үүлдэр угсааг нь сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх, иргэдийг малжуулах, ажлын байр бий болгоход санаачилга гарган ажиллаж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн

Баяндэлгэр сумын 3 дугаар багийн малчин Хоохногийн Магсарт Монгол Улсын гавъяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Жамцын Хишигсүрэнд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Орон нутгийн эмнэлгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээ үйлчилгээнд шинэ арга санаачлан нэвтрүүлж, мэс заслын эмчилгээг боловсронгуй болгох, эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэн эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлгийн ерөнхий эмч Жамцын Хишигсүрэнд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Даваажавын Лхагвадолгорт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, нүдний мэс заслын орчин үеийн шинэ аргуудыг өөрийн орны нөхцөлд чадварлаг нэвтрүүлэн нүдний клиникийн эмчилгээ үйлчилгээг сайжруулж, нүдний мэс заслын албыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Улсын клиникийн төв эмнэлгийн Нүд судлалын клиникийн эрхлэгч Даваажавын Лхагвадолгорт хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Гончигийн Жаргалсайханд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж олон арван нийтийн болон эстрадын дууны үг, ая зохион дуулж, уран сайхны кино, жүжгийн хөгжим бичиж, рок поп урлагийн залуу авьяастнуудыг бэлтгэх, Монголын эстрад урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчиллахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Соёл-Эрдэнэ"

хамтлагийн уран сайхны удирдаач Гончигийн Жаргалсайханд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Дэчинсандуйн Надмидад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, дархад хотгойд ардын дууг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, урын сангаа баяжуулан, ардын дууны урлагийг өөрийн орон төдийгүй гадаад оронд сурталчилах, хойч үедээ өвлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын ахмад дуучин Дэчинсандуйн Надмидад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Загдын Түмэнжаргалд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, утга зохиол, хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хүүхдийн болон зохиолын дууны шүлэг, өгүүллэг, яруу найргийн шилдэг бүтээлүүд туурвиж, сурган хүмүүжүүлэх зүйн ач холбогдолтой сурах бичиг, хүүхдийн зохиол бичиг, Монголын орчин

үеийн урлаг, утга зохиол, боловсролын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж яруу найрагч Загдын Түмэнжаргалд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх, санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт даалгасугай.

3. Хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрхэлсэн асуудлынхаа хүрээнд зохион байгуулан ажиллахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон нутгийн салбар зөвлөлийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэлд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙН САЙД**
М.ЭНХБОЛД
**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**
Ц.ЦЭНГЭЛ

байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.2.7. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

3.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2007-2010 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтод хүрэх зарчим, үйл ажиллагааны чиглэл

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээ нь төрөөс баримтлах бодлоготой уялдсан байна.

4.1.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна;

4.1.3. Хөтөлбөрийн зорилтыг хангах аливаа үйл ажиллагаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргэг, ослын шалтгаан, нөхцөл, нийгэм, эдийн засагт учруулж байгаа хор хөнөөлийн талаархи судалгаа, нотолгоонд үндэслэгдсэн энгийн, үр ашигтай байна;

4.1.4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэргэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлын чиглэл нь олон улсын байгууллагаас баримталж байгаа бодлого, чиглэлтэй нийцж тэдгээртэй хамтран ажиллана;

4.1.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хөдөлгөөнд оролцогчид хариуцлага, соёлтой оролцох ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.2.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.1.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийн нэгдсэн сан байгуулж, сүлжээний шуурхай байдлыг хангах,

4.2.1.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргэг, ослын шалтгаан, нөхцөлийг судлан дүн шинжилгээ хийж мэдээлэл, арга зүйн зөвлөмж, чиглэл боловсруулах;

4.2.1.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх;

4.2.1.4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны алба хаагчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, сонгон шалгаруулах ажлыг сайжруулах;

4.2.1.5. Дүрс бичлэгийн хяналтын системийг нэвтрүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний саатал, зам засварын ажлын талаархи мэдээллийг хөдөлгөөнд оролцогчдод шуурхай хүргэх;

4.2.1.6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн явган болон унадаг дугуй, ердийн хөсгөөр зорчигчдод ногдуулах захиргааны шийтгэлийн нөлөөллийг дээшлүүлэх.

4.2.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.2.1. Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, нийслэлийн авто замын сүлжээг 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан шинээр болон хоёр өөр түвшинд баригдах замын нөөц газруудыг тогтоох, эдгээр замыг дэс дараатай барьж эхлүүлэх;

4.2.2.2. Замын хөдөлгөөний ачааллыг судалж хөдөлгөөний зохион байгуулалтын оновчтой арга хэлбэрүүдийг ашиглан хөдөлгөөний саатлыг бууруулах;

4.2.2.3. Тээврийн хэрэгслийн зогсоолын асуудлыг хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан иж бүрэн шийдэх, ил болон далд зогсоолгүй барилгад газар олгохгүй байх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлэх;

4.2.2.4. Замын гэрэлтүүлгийн өнөөгийн түвшинг тоо, чанарын хувьд дээшлүүлж, шинэ гудамж, зам, хорооллуудыг заавал гэрэлтүүлэгтэй хүлээн авдаг журамд шилжих;

4.2.2.5. Явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нэг түвшний огтлолцлыг бууруулах чиг хандлагыг баримтлах;

4.2.2.6. Улс, орон нутгийн замд хөдөлгөөн зохицуулах замын тэмдэг, тэмдэглэл,

гэрлэн дохио шинээр тавих, засвар үйлчилгээ хийх системийг оновчтой болгох;

4.2.2.7. Замын сангийн хөрөнгийн зөрцуулалтыг ил тод, үр ашигтай болгож олон нийтэд мэдээлэх;

4.2.2.8. Хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зам, замын байгууламжийн эвдрэлийг шуурхай засч байх талаар норм, стандарт гарган мөрдүүлж, тавих хяналтыг чангатгах;

4.2.2.9. Гүйцэтгэгч байгууллагуудад тавих шаардлагыг өндөржүүлэх, зам засварын ажлын арга хэлбэр, хүртээмж, чанарыг сайжруулах;

4.2.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.3.1. Иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журмын мэдлэг, дадал, зуршил олгох ажлыг зохион байгуулах;

4.2.3.2. Хүүхдийг замын хөдөлгөөний ослоос урьдчилан сэргийлэх, тэдэнд замын хөдөлгөөнд оролцох дадал зуршил эзэмшүүлэхэд эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

4.2.3.3. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, давтан сургах ажлын чанарыг сайжруулах;

4.2.3.4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, стандарт, зам тээврийн осол гарч байгаа шалтгаан нөхцөл, тэдгээрээс үүссэн хохирлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх талаархи ажлын агуулга, хэлбэр, чанар, үр нөлөөг дээшлүүлэх;

4.2.3.5. Тээврийн хэрэгсэл эзэмшигч авто аж ахуй бүхий байгууллагуудад хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох.

4.2.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.4.1. Зам тээврийн осол, хэргийн тохиолдол бүрийг бүртгэх, байршил, цаг хугацааг нарийвчлан гаргаж судалгаанд хэмрүүлэх, эзэмч нөхцөлөөс шалтгаалан гарсан зам тээврийн осол, хэргийн судалгааг гаргаж, хариуцлага тооцдог болгох;

4.2.4.2. Гадаадын хөгжингүй улс орнуудын зам тээврийн осол, хэргийн судалгааны чиг хандлагын дагуу бүртгэл судалгааны арга механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;

4.2.4.3. Судалгааны үндсэн дээр зам тээврийн осолд явган зорчигч ихэвчлэн өртдөг газруудыг гарган урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.2.5. Хөтөлбөрийн үйл ажиллагааны тавдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.5.1. Тээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн байдалд судалгаа явуулж, үнэлэлт, дүгнэлт хийж, гааль, татварын бодлогоор зохицуулалт хийж;

4.2.5.2. Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтын бодлогыг боловсронгуй болгох;

4.2.5.3. Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд тавих шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

4.2.5.4. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг оношилгооны лабораторийн тусламжтайгаар чанарын өндөр түвшинд зохион байгуулах;

4.2.5.5. Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, бүрэн бүтэн байдлыг хангуулах.

4.2.6. Хөтөлбөрийн үйл ажиллагааны зургадугаар зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүргийг гүйцэтгэнэ:

4.2.6.1. Монгол Улсын Засгийн газар

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардлагатай зардлыг улс болон орон нутгийн төсөвт тусгах

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих.

4.2.6.2. Төрийн захиргааны төв байгууллага

Хууль зүй, дотоод хэргийн яам

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох

2. Хууль, дүрэм, шийдвэрийн биелэлтийг улсын хэмжээнд хангах талаар төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж удирдлага зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрх зүйн зөрчигд оногдуулах ял шийтгэл, захиргааны арга хэмжээг судлан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шуурхай байдлыг хангах

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албаны ажил, үйлчилгээ явуулах нөхцөлийг сайжруулах

5. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэг, ослын байдалд үнэлгээ дүгнэлт хийх.

Зам, тээвэр, аялал жуулчлалын яам

1. Замын хөдөлгөөний ачаалал, нягтрал ихсэж байгаа шалтгаан нөхцөлийн талаархи мэдээллийг судалж зам шинээр тавих, засварлах ажлыг чанартай, иж бүрэн зохион байгуулах

2. Замыг шинээр тавих, засварлах ажлыг хүн амын төвлөрөл, хөдөлгөөний нягтралтай уялдуулан хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлэх арга хэмжээ авах

3. Явган хүний гарц, нүхэн болон гүүрэн гарам байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих аятай нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд зориулсан зам талбай, тээврийн хэрэгсэлтэй болох

4. Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн техникийн стандарт, журам, үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулах, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх

5. Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлагыг хангахад чиглэгдсэн дэд хөтөлбөрийг мэргэжлийн албадтай хамтран боловсруулж хяналт тавьж ажиллах

6. Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохионы өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж стандартын шаардлагад нийцүүлэн ажил, үйлчилгээг зохион байгуулах

7. Замын сангийн хөрөнгийн төвлөрөлт, зарцуулалтыг иргэдэд ил тод болгож хяналтыг чангатгах

8. Тээврийн хэрэгслийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засварын ажил эрхэлдэг аж

ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, техникийн түргэн тусламжийн үйлчилгээг нэвтрүүлэх.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

1. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрэм, шийдвэрийг иргэдэд судлуулах чиглэлээр дэд хөтөлбөрийг мэргэжлийн албадтай хамтран боловсруулж сургалтыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих

2. Хөдөлгөөний аюулгүй байдлын талаархи хууль, дүрэм, шийдвэрийг сурталчлах анги, танхимыг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд байгуулах, сургалтын хөтөлбөрт оруулах, багш, сурган хүмүүжүүлэгч нарыг энэ чиглэлээр бэлтгэх, сургалт арга зүйн зөвлөмж, гарын авлага материалаар хангах

3. Замын хөдөлгөөнд оролцох дадал зуршлыг эзэмшүүлэх зорилгоор хүүхэд, өсвөр үеийнхний дунд зохиох ажилд дэмжлэг тусалцаа үзүүлэх

4. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, хөдөлгөөний соёл, эмнэлгийн анхан шатны тусламжийн хичээлийн агуулга, багтаамжийг оновчтой болгох

5. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хүүхэд, өсвөр насныхан холбогдож байгаа байдалд судалгаа явуулж, урьдчилан сэргийлэх ажилд багш, сурган хүмүүжүүлэгч, цэцэг эхийн хяналт, оролцоог дээшлүүлэх.

Эрүүл мэндийн яам

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос гэмтсэн, нас барсан хүмүүсийн талаархи судалгаа гаргаж, урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

2. Тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо хэрэглэхийг хориглох эм, эмийн бэлдмэлийн жагсаалтыг гаргаж иргэдэд сурталчлах

3. Жолоочийн эрүүл ахуйн нөхцөлийг судалж, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмж гаргаж сурталчлах

4. Тээврийн хэрэгслийн жолоочийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журам, зааврыг боловсронгуй болгох, эмнэлгийн түргэн

тусламжийн үйлчилгээг оновчтой шуурхай зохион байгуулах

5. Зам тээврийн осолд өртөгсдөд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг нийт иргэдэд олгох, сурталчлах ажлыг эрчимжүүлэх, холбогдох сургалтын хөтөлбөрүүдэд тусгаж хэрэгжүүлэх.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

1. Жолоочийн хөдөлмөрийн нөхцөлийг орон нутаг, цаг уурын нөхцөлийн онцлогтой холбон судлах, нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн жолоочийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлийн онцлогийг судалж мэдээлэл, сургалт явуулах

2. Зам тээврийн ослын улмаас учирч байгаа хохирлын хэмжээг жил бүр тооцон гаргаж холбогдох байгууллагуудад мэдээлэх.

Сангийн яам

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байх

2. Хөтөлбөрийн хүрээнд гадаад дотоодын байгууллага, хандивлагчидтай хамтран дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар дэмжлэг үзүүлэх.

Гадаад хэргийн яам

1. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээрх гадаад орны туршлага, амжилтын тухай мэдээллийг мэргэжлийн байгууллагад өгөх

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орон болон бусад байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Барилга, хот байгуулалтын яам

1. Барилгын зураг төслийг зохиоходоо тээврийн хэрэгслийн зогсоол, замын хөдөлгөөний стандартыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих

2. Хот төлөвлөлтийн асуудалд замын хөдөлгөөнийг тусгахдаа тодорхой судалгааны үндсэн дээр зураглалыг төлөвлөж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай байдлыг хангасан норм, хэм хэмжээг тусгах.

4.2.6.3. Цагдаагийн ерөнхий газар

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг судлах аргачлалыг боловсронгуй болгож гарч байгаа хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албаны албан хаагчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны техник хэрэгсэл, ажлын байрны нөхцөлийг судалж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөл, хөдөлгөөний сааталд дүн шинжилгээ хийж зохих арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах

5. Жолооч болон тээврийн хэрэгслийн бүртгэлийн сүлжээг бусад мэдээллийн сүлжээтэй холбох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох

6. Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж хэрэгжүүлэх

7. Хөдөлгөөнд оролцогчдоос замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн зөрчлийн тухай мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээ хүлээн авах системийг боловсронгуй болгох, байгууллага, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжих, урамшуулах.

4.2.6.4. Мэргэжлийн байгууллагууд

Улсын мэргэжлийн хяналтын газар

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээрт нийцүүлж гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах

2. Замыг шинээр тавих, засварлах ажлын үр дүнд чанарын үнэлгээ өгч ажиллах

3. Жолооч бэлтгэх сургууль, дамжаанд сургалтын хөтөлбөрийг хэрхэн хангаж байгаад хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгч ажиллах

4. Тээврийн хэрэгслийн оношилгоо, техник үйлчилгээний газрын үйлчилгээнд хяналт тавьж ажиллах.

Стандартчилал, хэмжил зүйн төв

1. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой стандартуудыг шинэчлэх болон шинээр боловсруулж мөрдүүлэх

2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран тээврийн хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээг явуулах газрын үйлчилгээний стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, хяналт тавьж ажиллах.

Даатгалын байгууллагууд

1. Хариуцлагын даатгалыг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, ослын газар дээр даатгалын байгууллага /байцаагч/ очиж хохирлыг хурдан шуурхай барагдуулдаг эрх зүйн орчинг бүрдүүлэх

2. Даатгалын байгууллагад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй болох, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх ажлыг зохион байгуулах.

4.2.6.5. Хэвлэл мэдээллийн байгууллага

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг нийтлэл нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт тусгаж, тэдгээрийн цагийг нэмэгдүүлэх, түүнчлэн захиалагчдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, үнэ төлбөргүй нэвтрүүлэг явуулах боломжийг судалж шийдвэрлэх.

4.2.6.6. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга

1. Хөтөлбөрийн зарчим, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлж орон нутгийн хөдөлгөөний аюулгүй байдлын онцлог, тулгамдсан асуудалтай уялдсан дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих

2. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог дээшлүүлж, санал санаачилгыг дэмжих бодлого баримтлах

3. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаарддаг хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлж байх

4. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, хөдөлгөөний саатагд судалгаа явуулж замын хөдөлгөөний зохион байгуулалт болон зам шинээр тавьж, засварлах ажлыг эрчимжүүлж шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх

5. Хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

6. Замын зорчих хэсэг, явган хүний замын гадаргуугийн арчлалт, хамгаалалт, цэвэрлэгээний ажлыг шуурхай зохион байгуулж, замын хөдөлгөөний хэвийн нөхцөлийг бүрдүүлэх.

7. Нийтийн эзэмшлийн газар, ялангуяа явган хүний замыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн бүсийг тогтоон аюулгүй байдлыг хангах, газар олголт, хот төлөвлөлтийн бодлогод хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлыг тэргүүн ээлжинд анхаарч тусган хэрэгжүүлэх

8. Автомашины гарааш, зогсоолын талаар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

4.2.6.7. Аж ахуйн нэгж, байгууллага

1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд соёлтой оролцох талаар ажиллагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжин туслах талаар санаачилж ажилласан нэгж, ажилтны үйл ажиллагааг дэмжин сурталчлах

2. Стандартын шаардлага хангаагүй, техникийн гэмтэлтэй, техникийн улсын үзлэгт ороогүй, улсын бүртгэлд хамрагдаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх

3. Тээврийн хэрэгслийн ангилалд тохирсон жолоодох эрхийн үнэмлэхгүй, согтууруулах ундаа, мансуурах бодис, сэтгэхүйд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчин туссан буюу ядарсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албатай хамтран замын хөдөлгөөний хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байх үйл ажиллагааг хэрэгжүүлэх

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах санал, санаачилга гаргаж холбогдох

газруудад тавьж шийдвэрлүүлэн энэ чиглэлээр мэдээлэл солилцох боломжийг ашиглах.

4.2.6.8. Төрийн бус байгууллага

1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг өөрийн үйл ажиллагааны чиглэлд тусган оролцох, бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх.

4.2.6.9. Иргэн

1. Хуулийг дээдлэх иргэний үүргээ биелүүлж замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажилд хувь нэмрээ оруулах

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гарсан хэрэг, осол, зөрчлийн талаархи мэдээллийг холбогдох газруудад өгөх, хяналт, шаардлага тавих

3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас үүсэх хор хөнөөлийн талаар зохих мэдээлэлтэй болж гэр бүл, хүүхэд, халамжлан хүмүүжүүлэгч нартаа тайлбарлан таниулж биет үлгэр дууриалал үзүүлэх

4. Өөрийн амьдарч байгаа орчиндоо замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл бүрдүүлэх талаар холбогдох эрх бүхий хүмүүс, байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхтэй холбогдсон бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавих үүргийг Үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөлийн бүрэлдэхүүнийг тээврийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

5.3. Аймаг, нийслэл, дүүрэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулна.

5.4. Яамд, Засгийн газрын агентлаг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагад хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилогдсон салбар зөвлөл хариуцна.

5.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөөг Үндэсний зөвлөл батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана.

5.6. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

а/нутаг дэвсгэрийн түвшинд Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг боловсруулж мөрдүүлэх;

б/хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

в/орон нутагт хуваарилсан төсөв, замын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилж, зарцуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах;

д/хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

5.7. Салбар зөвлөлүүд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг улирал, хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлд тайлагнана.

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

6.1. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч байгаа хохирлын хэмжээ буурна.

6.2. Замын хөдөлгөөний зохион байгуулалт, замын нөхцөл сайжирч, хөдөлгөөнд соёлтой оролцох таатай орчин бүрдэнэ.

6.3. Замын хөдөлгөөнд оролцогчид болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагч, албан тушаалтны мэдлэг, чадвар, хариуцлага дээшилнэ.

6.4. Хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөө, амьд явах эрх баталгаажна.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоронгийн эх үүсвэр, санхүүжилт

7.1. Улсын төсөв

7.2. Орон нутгийн төсөв

7.3. Олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламж

7.4. Иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

8.1. Хяналт, үнэлгээ

8.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийх ажлыг Цагдаагийн ерөнхий

газар, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжтэй хамтран гүйцэтгэж Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна.

8.1.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга хамтран гүйцэтгэж, дүнг жил бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон нутгийн салбар зөвлөлд тайлагнаж, авах арга хэмжээг эрчимжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

8.2.1. Хэрэг, ослын үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт		Суурь үзүүлэлт /2005 он/	Завсрын үзүүлэлт /2007 он/	Эцсийн үзүүлэлт /2010 он/
1.	Мянган тээврийн хэрэгсэлд ногдох	зам тээврийн осол, хэргээс гэмтсэн хүний тоо	6.4	6.2	6.0
2.		зам тээврийн осол, хэргээс нас барсан хүний тоо	2.2	2.0	1.8
3.		зам тээврийн хэрэг, ослоос учирсан эд материалын хохирол /мян. төг/	2231.2	2200.0	2100.0
4.	Мянган тээврийн хэрэгсэлд ногдох осол хэргийн шалтгаан	явган зорчигчийн буруу	17.6	16.0	15.0
		Жолооч хажуугийн зай тохируулаагүй	10.0	9.0	8.0
		Жолооч уулзвар нэвтрэх дүрэм зөрчсөн	13.1	12.1	10.1
5.	Мянган хүнд ногдох осол, хэргийн тоо		1.9	1.8	1.7

8.2.2. Замын хөдөлгөөний зохион байгуулалт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2005 он/	Завсрын үзүүлэлт /2007 он/	Эцсийн үзүүлэлт /2010 он/	
1.	Суурын газарт 1 км ² нутаг дэвсгэрт ногдох авто замын сүлжээний урт	0,11 км	0,13 км	0,15 км	
2.	Гудамж замын гэрэлтүүлгийн хувь	75,0	85,0	95,0	
3.	Зам, гүүр, уулзварын цагт дунджаар нэвтрүүлэн өнгөрүүлэх тээврийн хэрэгслийн тоо	3185-8414	3190-8450	4000-9500	
4.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим /1 цагт дунджаар/	26323-68171	28500-73000	30000-75000	
5.	Явган зорчигчдод зориулсан замын урт	Одоогоор судлагдаагүй	Судалгаатай болно	Замын уртыг нэмэгдүүлнэ	
6.	Замын	Тэмдэг	4000	4500	5000
		Гэрлэн дохио бүхий уулзвар	52	60	65
		Тэмдэглэл	20000 м.кв	21000 м.кв	22000 м.кв
7.	Явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тусгаарлах нүхэн болон гүүрэн гарам	Нүхэн гарам	1	2	3
		Гүүрэн гарам	1	2	3

8.2.3. Замын хөдөлгөөнд иргэдийн оролцооны үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2005 он/	Завсрын үзүүлэлт /2007 он/	Эцсийн үзүүлэлт /2010 он/
1.	Мянган тээврийн хэрэгсэлд ногдох замын хөдөлгөөний дүрмийн зөрчил	4432,3	4410,0	4380,0
2.	Мянган жолооч тутмаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил	72,0	70,0	68,5
3.	Мянган тээврийн хэрэгсэлд ногдох бүрэн бус тээврийн хэрэгсэл	629,0	610,0	590,0

8.2.4. Замын хөдөлгөөний зохион байгуулалт сайжирч, хөдөлгөөний соёл дээшилсэн байна.

8.2.5. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан, нөхцөл, орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байна.

8.2.6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм сурталчлах ажил хүртээмжтэй болж, сургалт, сурталчилгааны багтаамж 10 хувиар өссөн байна.

8.2.7. Замын хөдөлгөөн зохицуулах ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлнэ.

Засгийн газрын 2006 оны 315 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Л/д	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Санхүүжилтийг харууцах байгууллага	Арга хэмжээг зохион байгуулах байгууллага
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын удирдлага, зохион байгуулалт, хяналтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд				
1	Хөдөлгөөний хэрэгжүүлэх аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлүүдийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах	2007 - 2010	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	ХЗДХЯ, ЭТАЖЯ, Аймаг, нийслэлийн ИТХ
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ослын шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоож, нийгэм, иргэдэд учрах хор, кохирлыг багасгах оновчтой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2007	ЦЕГ	ЦЕГ, ЗЦГ
3	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албыг бэхжүүлэх санал боловсруулж шийдвэрлүүлэх	2007 - 2008	СЯ, ЦЕГ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	ХЗДХЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаж сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээтэй болгох, сүлжээний шуурхай байдлыг хангах арга хэмжээ авах	2007 - 2008	ХЗДХЯ, ЭТАЖЯ	ХЗДХЯ, ЭТАЖЯ
5	Эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбар гаргуулах талаар санал боловсруулах	2007	ЦЕГ	ХЗДХЯ
6	Тээврийн хэрэгслийн гатвар, жолоочийн хариуцлагын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх	2007 - 2008	ЦЕГ, УТЕГ, УНДГ	СЯ, ХЗДХЯ
7	Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлын удирдлага зохион байгуулалт, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилгоор гадаад орнуудад туршлага судлах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	2007 - 2008	ЭТАЖЯ, ЦЕГ	ХЗДХЯ, ЭТАЖЯ
8	Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөтгөх аялан галт арга хэмжээг хэрэгжүүлж үнэлэлт дүгнэлт өгч байх	2007 - 2010	ЦЕГ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	ХЗДХЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
9	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчигчдэд хүлээлтэй эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатгах, зөрчигчд нь тохирсон арга хэмжээг авч эмхлэх	2007	ЦЕГ	ХЗДХЯ
10	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, тогтоомж зөрчигчдөд бэлэн бусар туршууль ногдуулах арга хэмжээг судалж хэрэгжүүлэх	2007	СЯ, ЦЕГ	ХЗДХЯ

ХЭДХЯ, ЦЕГ	ЗЦГ	2007 - 2010	ХЭДХЯ, СЯ, ЗТАЖЯ
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албаны алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг боловсрол, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, сонгох шалгаруулах төлөвлөгөө гарган давшан болон зайны сургалтыг зохион байгуулах	ЗТАЖЯ, Нийслэлийн Засаг дарга	2007 - 2008	ХЭДХЯ, СЯ, ЗТАЖЯ
Замын хөдөлгөөнд тавих хяналтыг боловсронгуй болгох зорилгоор дүрс бичлэгийн хяналтын систем ашиглах шинэ дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх, хууль хяналтын байгууллага, иргэдэд хүргэх мэдээллийг шуурхай болгох	ЦЕГ	2007 - 2010	СЯ, ХЭДХЯ
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албаны алба хаагчдын цагийн нийгмийн хэргэмжийг сайжруулах арга хэмжээ авах	СЯ	2007 - 2010	Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар, ЗЦГ
Хэрэг, ослорог урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний саатлыг багасгахад чиглэгдсэн хөдөлгөөн зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх	СЯ	2007 - 2010	СЯ
Иргэний ах үеэсрийг шийдвэрлүүлэх	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор замын хөдөлгөөний тээвэр нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд		
Нийслэлийн авто замын сүлжээ 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөнд нэвчлэгдсэн шинээр болон хоёр өөр төвшинд баригдах замын нөөц газруудыг тоолох хаалгах, эдгээр замыг дэс дараатай баруулах	Нийслэлийн Засаг дарга	2007 - 2010	БХБЯ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Газрын хэрэгслийн зогсоолын асуудлыг хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан иж бүрэн шийдэх, долно, гадна талд автомашин зогсоолын талбайгүй барилгад газар олголт хийхгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2007 - 2008	БХБЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
Аймаг, нийслэлийн гудамж, замын гэрээтүүлийг сайжруулах, гэрэлтүүлгийг дэс дараатай авч хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар	2007 - 2010	ЦЕГ
Автозамын хөдөлгөөний ачааллын байдлыг харгалзан гудамж, зам талбайг баруулах, шинэчлэх засварлах, тэмдэг, тэмдэглэл, гэрэл дохио тавих ажлыг улсын төсөв, замын сангийн хөрөнгөөр хийлгэх	СЯ	2007 - 2010	Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгын газар
Нийслэл, орон нутгийн замын санг хуулийн дагуу бүрдүүлж, автозам, замын байгууламжийг засаж арчлах, тэмдэжүүлэх, хамгаалахад зарцуулах	ЗТАЖЯ, Сангийн яам	2007 - 2010	ЗТАЖЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
Хөдөлгөөний аюулгүй байдалд өргөтөө нөлөөлөх зам, замын байгууламжийн бодирлыг шуурхай засаж байх талаар орон нутаг, нийслэлийн замд мөрдөх норм стандарт гаргаж хэрэгжүүлэх. Энэ ажилд тавих хяналтыг тогтмолжуулах, үр нөлөөг дээшлүүлэх	ЗТАЖЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	2007 - 2008	ЗТАЖЯ, ЗЦГ, УМХГ
Олон улсын болон улсын чанартай замуудад хяналт, арчлалт хийж байх үйлчилгээ зэвгэлтэй бий болгож ажиллуулах. Нийслэлийн замыг хариуцах зөвнөтэй болгох	Нийслэлийн Засаг дарга нар	2007 - 2008	ЗТАЖЯ, УМХГ, ЦЕГ, Нийслэлийн ЗДТ
Автозамас шалтгаалан гарч байгаа ооол аваарын тухай мэдээллийг замын чиглэл бүрээр гаргаж холбогдох арга хэмжээг авах	ЗТАЖЯ, ЗЦГ	2007	ЗТАЖЯ, ЗЦГ

	2007 - 2010	2007 - 2010	2007 - 2010	2007 - 2008	2007 - 2008	2007	2007 - 2010	2007 - 2010	2007 - 2008
Явган зорчигчид зориулсан нүхэн болон пүүрэн гармуудыг байгуулах тэдний хөдөлгөөнийг тусгаарлах хайс, хашлага, чиглүүлэх байгуулалыг хийлгэн ашиглах замаар явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг огтлолцлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	2007 - 2010	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар	ЗТАЖА, Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар
23									
24									
25									
26									
27									
28									
29									
30									
31									

Хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёл, харьцуллагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд

Ургасд замын хөдөлгөөнийг аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн мэдлэг, хөдөлгөөнийг зориулсан сургалтыг зохион байгуулах дэд хөтөлбөр гаргаж, хүүхдийг замын хөдөлгөөнийг өндөржүүлэх зорилгоор 1-10-р ангийн хүүхдэд зориулсан суралт бичиг, багш нарт зориулсан зах арга зүйн гарын авлага, хүүхдэд зориулсан төстийн номыг бэлтгэн гаргаж, ЕБС-ийн хичээлийн программд оруулж хэрэгжүүлэх

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх давтан сургалтын системийг боловсронгуй болгох

Замын хөдөлгөөнийг аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, стандарт болон гарч байгаа зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, Тэдгээрээс үүссэн хохирлын талаар хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлж, хэрэг, ослос урьдчилан сэргийлэх талаархи ажлын агуулга, хэлбэр, чанар, үр нөлөөг дээшлүүлэх

ЗЦГ-ын дэргэд телевиз, радиогийн студийг бий болгож замын хөдөлгөөнд иргэн бүрийг соёлтой оролцох, замын хөдөлгөөний дүрийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор радио, теле нэвтрүүлэг, санамж зөвлөмж, сэрэмжлүүлэг тогтмол явуулах

Тээврийн хэрэгсэл эзэмшигч авто аж ахуй бүхий байгууллагууд замын хөдөлгөөнийг аюулгүй байдлын тухай хуулиар хүлээн үүргээ биелүүлэгүй тохиолдолд хүлээлгэх харуцлагын тогтолцоог боловсронгуй болгох

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцлийг судлах судалгааг боловсронгуй болгож тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зэрэгт хэрг, ослын шалтгаан, нөхцлийг судлах судалгааны арга зүйг боловсронгуй болгох, судалгаа дүн шинжилгээний ажигд шинэ Давшилтэт технологи нэвтрүүлэх	2007 - 2008	ЗЦГ	ХЗДХЯ, ЗТАЖЯ, ЦЕГ
Замын нөхцлөө шалтгаалан гарсан зам тээврийн ослон, хэргийг арилгуулах	2007 - 2010	ЗТАЖЯ, ЦЕГ	ЗТАЖЯ, ЦЕГ
Зам тээврийн ослон явган зорчигч олонтаа ертдөг газруудын судалгаа гарган үзүүлж чиглэн сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	2007 - 2010	ЗЦГ	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ЗЦГ
Зам тээврийн ослон, хэргийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох. Суурин болон хөдөлгөөнт хэлбэрийн цахим сүлжээг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийг цуглуулах, шалгах.	2007 - 2010	ЦЕГ	ХЗДХЯ, ЗЦГ
Зам тээврийн ослон, хэргийн мэдээллийг талархи мэдээллийг цуглуулах, шалгах, шийдвэрлэх ажиллагаанд ашиглах.			
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчсөн жолооч, хөдөлгөөнд оролцогчдын талар харьяалах байгууллага, хороо, багт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын албанаас мэдэгдэл, шаардлага өгч, урьдчилан сэргийлэх ажил зохиолгон хариу авах аявдлыг хэвшил болгох.	2007	ЗЦГ	Аймаг, нийслэл, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс

Тээврийн хэрэгслийн техникийн шаардлага, ашиглалт, аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд

Тээврийн хэрэгслүүдийн ашиглалт, техникийн байдалд судалгаа явуулж, гааль, тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох.	2007 - 2010	ЗТАЖЯ	ЗТАЖЯ, ХЗДХЯ, СЯ
Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох. Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох. Тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох.	2007 - 2010	ЗТАЖЯ, ЗЦГ	ЗТАЖЯ, ЗЦГ
Тээврийн хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээг явуулах газруудын үйлчилгээний стандарт, нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд тавих шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, зөвшөөрөгчтэйгээр хуулийн тээвэр хийх явдлыг таслан зогсоох, хүлээлтэй харьцуулах чангалгах.	2007 - 2008	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	ЗТАЖЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар, СХЗУТ
Тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг оношлогооны зориулалтын багаж, үзлэг оношлогооны тусламжтайгаар чанарын өндөр түвшинд зохион байгуулах.	2007	ЗТАЖЯ	ЗТАЖЯ
Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ эрхлэгчдэд тавих шаардлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах.	2007 - 2008	ЗТАЖЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар	ЗТАЖЯ, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд
Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөг
хуваарилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
16.20 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Ж.Амарсанаа, Ч.Дашням, Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны иргэн Н.Хайдав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Р.Буд, Т.Очирхүү нар оролцов.

Нэг. Иргэн Н.Хайдав Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэлдээ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалт нь Засаг төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэл өөрсдөдөө онэгдсөн /хуулиар зөвшөөрөгдсөн/ эрх, үүргээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчмыг дээдлэн, чандлан сахих, сахмулах баталгаа гэж үзэж байна.

Энэхүү зарчмыг Үндсэн хуулийн төрийн байгуулал гэсэн гуравдугаар бүлэгт, Нэг Монгол Улсын Их Хурал, Гурав Монгол Улсын Засгийн газар, Дөрөв Шүүх эрх мэдэл хэмээн тусгайлан зааж тус бүрийнх нь эрх, үүргийг зааглан тогтоож өгсөн байна.

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь заалт нь төрийн эргэлт, хувьсгал гэх мэт хүчирхийллийн аргаар Засаг төрийн эрх мэдлийг булаан авсан, авахаар завдсан үйл ажиллагаанд л хамаатай мэтээр авч үзэх нь утгагүй юм. Учир нь иймэрхүү үйл ажиллагааны үр дагаварыг Үндсэн хуулийн цэц /шүүх/ хянан хэлэлцэж, шийдвэрлэх боломжгүй бөгөөд өөрөө тэрхүү хүчирхийллийн золиос болж эрх мэдлээ алдах нь ч бий, харин хянан хэлэлцэж болохуйц нөхцөл байдалд л Үндсэн

хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэгдсэн гэж үзэж байна.

"Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно" гэж Үндсэн хуулийн /гуравдугаар зүйл/-д заасан нь зөвхөн "зэвсэглэн халдах" гэсэн утга биш, "сонгууль /санал/ луйвардах" мэт ч хамаатай.

Б.Чимид Өнөөгийн "Улс төр хуульчийн нүдээр" номондоо дээр дурдсан гурван эрх мэдлийн аль нэг байгууллага тэдгээрийн албан тушаалтнуудаас эрх мэдлээ хэтрүүлэн бусад эрх мэдлийн эрх, үүрэгт халдан хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж болох боломжийг өөртөө бий болгосон нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөнийг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэх боломж үйл ажиллагаа, нөхцөл, байдал гэж үзэж байна.

Монгол Улсын 2007 оны нэгдсэн төсвийг хэлэлцэн батлахдаа, төсвийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд оруулах Засгийн газрын онц эрхийг зөрчин зарим гишүүд санаачлан Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөг хуваарилан шадар сайдын багцад суулган, Улсын Их Хурлын гишүүдийн эрх мэдлээр захиран зарцуулах анхны санаачлага олон нийтийн ихээхэн эсэргүүцэлтэй тулгармагц "зүсийг" нь буруулж, зүйлг нь даялуулан Улсын Их Хурлын гишүүдээр жагсаалт гаргуулан, сайд нарын багцад тараан байршуулах замаар биелэлээ олж батлагдсан байна.

Ийнхүү олон нийтийн төдийгүй Улсын Их Хурлын гишүүдийн хувьд ч маргаантай байсаар байгаа асуудлыг нэг мөр эцэслэн шийдвэрлүүлж, Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Анхлан 10 саяар эхэлж, өнгөрсөн жил 100 сая, өдгөө 250 сая боллоо осон, үржиж хэвийн үзэгдэл, жишиг болон тогтож Үндсэн хуулиар тогтоосон Засаг

төрийн эрх мэдэл хуваарилсан зарчим ноцтойгоор зөрчигдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Засаг төрийн гүйцэтгэх болон орон нутгийн өөрийн удирдлагын бүрэн эрхэд халдан Улсын Их Хурлын төсвийн байнгын хороогоор хэлэлцэн Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт, Улсын Их Хурлын гишүүн бүрт 250 сая, бүгд 19 тэрбум төгрөгийг хуваарилан, гишүүдийн гаргасан жагсаалтаар сайд нарын багцад суулган баталсан Улсын Их Хурлын 2006 оны 11 дүгээр 30-ны өдрийн шийдвэр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүдийн гаргаж өгсөн жагсаалтаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хэлэлцэж Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийг хуваарилан салбар хариуцсан сайд нарын 2007 оны төсөвт оруулж баталсан /бүгд 19 тэрбум төгрөг/ Улсын Их Хурлын 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрийг хянан хэлэлцэж, хүчингүй болгож, Үндсэн хуулийг чандлан сахиулахыг хүсэе гэжээ.

Хоёр, Улсын Их Хурлын даргын 2007 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар захиралжаар томилсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Буд, Т.Очирхүү нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа :

"...Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 7, дөрөвдүгээр бүлгийн 10 дахь заалт, дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дугаар хавсралтад заасан 2007 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй талаар дараахь дэлгэрэнгүй тайлбарыг өгч байна:

1. Нэгдүгээр зүйлийн 2. "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг зөрчсөн тухайд:

Монгол төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь шударга ёс юм. Шударга ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга бол аливаад алагчлахгүй хандаж шийдвэрлэх явдал билээ. Монгол Улсын

Их Хурал үйл ажиллагаандаа Үндсэн хуулийн энэ заалтыг гуйвалтгүй мөрдөн ажиллаж байгааг энэ дашрамд тэмдэглэх нь зүйтэй юм.

Төрийн үйл ажиллагаанд тэгш байдлын зарчим нь юуны өмнө төр, иргэн хоёр харилцан тэгш үүрэг хариуцлага хүлээх байдлаар хэрэгждэг. Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим нь хууль тогтоомжийг боловсруулах, батлах үйл ажиллагаанд Үндсэн хуулийг дээдлэх явдал гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурал 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан билээ.

Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийн төслийг хэлэлцэн батлахдаа Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийг дээдлэн, хуулийн холбогдох заалтыг иш үндэс болгосон юм. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж заасан бөгөөд энэ зүйлийн 7-д "төрийн санхүү, эзл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэж заасан байдаг бөгөөд энэ бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурал төсвийн төслийг хэлэлцэн баталсан.

Мөн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33 дугаар зүйлд Улсын Их Хурал улсын төсөв батлахдаа төсвийн дор дурьдсан баримт бичиг, хуулийн төслийг хэлэлцэн батална гэж заасан. Үүнд:

"33.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт дараахь зүйлийг тусгана:

33.2.1. улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бусад этгээдээс худалдаж авах бүтээгдэхүүнийг анги бүрээр;

33.2.2. улсын төсвөөс төлөх гэтгэвэр, тэтгэмж, бусад зэрлэгийн төрөл, анги бүрээр;

33.2.3. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад зардлыг зардлын төрөл бүрээр.

33.2.4. улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын төсөл бүрээр.

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтын хуваарилалтыг хийхдээ орон нутгийн санал, ард түмний элч, иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзсан нь тэдгээрийн сонгогчдын шууд эрх ашгийг нь хамгаалах, хүн амын тоог харгалзсан нь нийт иргэдэд төсвийн хөрөнгө тэгш шударгаар хуваарилагдах зарчмаас урган гарч байгаа бөгөөд ингэснээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэгш байдал, шударга ёсны зарчимд нийцрж байгаа болно.

2. Гуравдугаар зүйлийн 2. "Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар завдах гэдэг нь уг эрх мэдлийг хууль бусаар авах зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг ойлгодог билээ. Ийм үйл ажиллагааны хэлбэр нь төрийн эрх мэдлийг авах зохион байгуулалттай ажиллагаа хийсэн тухайлбал, бослогод бэлтгэх, олон нийтийг хамарсан самуун дэгдээх, засгийн эрх мэдлийг авах ажиллагааг удирдан зохион байгуулсан зэрэг үйл ажиллагаа байдаг.

Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийг хэлэлцэн батлах үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн энэ заалтад хамаарах ямар нэг үйл ажиллагаа болоогүй бөгөөд гагцхүү Үндсэн хуулиар олгогдсон онц бүрэн эрхийнхээ дагуу ажилласан болохыг гэмдэглэн хэлэх байна.

3. Гучин наймдугаар зүйлийн 2.2. "шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Засгийн газар нь Үндсэн хуулийн энэ заалтад заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон

бусад хуульд заасан тодорхой эрхийг хэрэгжүүлдэг. Энэ дагуу Улсын Их Хурлаас баталсан 2007 оны төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2007 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа эдийн засагт гарсан таатай нөхцөл, гадаад зах зээлийн үнэ ханшийн өсөлтийн улмаас бий болж байгаа санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг хуримтлуулж, бодит салбарыг хөгжүүлэх дэд бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалт хийх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан төсвийн бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг индексжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, түүний хүртээмж, тоо чанарыг ахиулахад анхаарсан юм.

Улсын Их Хурал Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийг батлан гаргахдаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33.2.4-ийг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2007 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж бүрээр жагсаалтыг баталсан. Энэ ажиллагаа нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн биш харин Үндсэн хуулийн энэ заалтын хүрээнд явагдсан ажиллагаа гэж үзэж байна.

4.Жаран хоёрдугаар зүйлийн 1. "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна"; Жаран хоёрдугаар зүйлийн 2. "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэх үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно" гэж тус тус заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Монгол Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх тодорхой хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг Улсын Их Хурлын гишүүд болон аймаг, нийслэлийн ИТХ-ын саналыг үндэслэн төсөв захирагчдын багцаар дэмжүүлэн баталсан нь төсвийн харилцааг зохицуулсан Төсвийн байгууллагын удирдлага,

санхүүжилтийн тухай хууль, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон хууль тогтоомжийн хүрээнд нийцэж байгаа юм.

Аливаа сонгогчид өөрийн мандатаар дамжуулан эрх ашиг, сонирхлоо илэрхийлдэг нь дэлхий нийтэд тогтсон жишиг юм. Улсын Их Хурлын гишүүд ч тухайн тойргийнхоо бус нутгийн хөгжил, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой санал гаргаж Улсын Их Хурлаар дэмжүүлэн батлуулж байгаа нь энэхүү жишгийг дагасан хэрэг болно.

Монгол Улсын 2007 оны төсвөөр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ийнхүү баталж байгаа нь нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдэж байгаа бус гагцхүү Улсын Их Хурал өөрт Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн байна. Ийм учраас Үндсэн хуулийн энэ заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл байхгүй байна.

5. Далдугаар зүйлийн 1. “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн тухайд

Дээр дурдсан тайлбаруудаас үзвэл Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7, дөрөвдүгээр бүлгийн 10 дахь заалт, дөрөвдүгээр бүлгийн 11 зүйлийн нэг, хоёрдугаар хавсралтад дурдсан 2007 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтууд нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд улсын төсвийн байгууллага, ард иргэдийн эрх ашигт бүрэн нийцсэн хэрэгжих бүрэн үндэстэй шийдвэр гэж үзэж байна.

Энэ бүхнээс үзэхэд Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль болон бусад хуулиудад нийцэж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдсэн асуудал тул Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаагаа үүгээр тайлбарлаж байна” гэжээ.

Гүрээ Ирсэн Н. Хэлдэв 2006 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зэргэсэн нэмэлт тайлбарлээ.

“Улсын Их Хурлын гишүүн бүрийн гаргасан жагсаалттай танилцаагүй боловч “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийг батлахдаа гишүүн бүр тойрогтоо 250.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалт нэрээр салбарын сайд нарын төсвийн ерөнхийлөн захирагчдын/ багцад тараан байрлуулж баталсан нь миний өргөдөлдөө дурдсан баримтууд болон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тайлбараас тодорхой байна.

1. “Шударга ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга бол аливаад алагчлахгүй хандаж шийдвэрлэх явдал” гэснийг зөвхөн үүгээр хязгаарлан, хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай юм. “Заасг төр бол Үндсэн хууль хийгээд бусад хуулийг ягштал мөрдөж, түүний “хүрээнд” биш яг зааснаар нь ажилладаг /заалтаас гажвал эрхээ хэтрүүлсэн, үүргээ умартсан хэрэг болно/. Иргэд бол хуулиар хориглоогүйг хийж чөлөөтэй амьдардаг” байх нь Үндсэн хуулиар тунхаглан тогтоосон Улсын Их Хурлаас үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ардчилсан ёс, шударга ёсны зарчим бөгөөд аливаа хуулийг зөрчөөгүй, зөрчихгүй байх нь шударга ёсны үнэлэмж гэж үзэж байна.

2. Төрийн үйл ажиллагаанд тэгш байдлын зарчим нь юуны өмнө төр, иргэн хоёр харилцан тэгш үүрэг хариуцлага хүлээх байдлаар хэрэгждэг” гэснийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү юм. Учир нь төр, иргэн хоёр нь Үндсэн хууль болон бусад хуулиар өөр өөр үүрэг хүлээж, эрх эдэлдэг бөгөөд тэр л эрх үүргийнхээ дагуу хариуцлага хүлээдгийг ингэж хялбарчилж боломгүй.

3. Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим нь хууль тогтоомжийг боловсруулах, батлах үйл ажиллагаанд Үндсэн хуулийг дээдлэх явдал гэж үзэж байна” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Энд төр гэдэгт зөвхөн Улсын Их Хурал ч хамаардаг бус гэдгийг ойлгоогүй эсвэл ойлгохыг хүсээгүй бололтой. Хууль дээдлэх гэдэг нь зөвхөн хууль боловсруулах, батлах үйл ажиллагаанд төдийгүй түүнийг хэрэгжүүлэх, хянах бүхий л үйл ажиллагаанд хуулийг дагаж мөрдөх, ягштал биелүүлэх тухай ойлголт гэж үзэж байна.

4. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг хэлэлцэж болох” гэж заасан нь өөрийн эрх мэдэлд хамаарахгүй асуудлыг булаан авч шийдвэрлэж болох тухай ойлголт биш харин алдаа, оноог хэлэлцэн эрх мэдлийн бусад байгууллагаг шаардлагатай гэж үзвэл төсөл, шийдвэртээ тусгаж байх тухай ойлголтоос энгид авч үзэж боломжгүй юм. Мөн зүйлийн 7-д “... улсын

төсөв... батлах" гэсэн заалт нь Засгийн газарт хамаарах Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2 "...улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг бодовсруулж, Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" гэсэн эрхэнд халдан улсын төсвийг зохиож батлах гэсэн ойлголт биш юм. Харин Засгийн газраас боловсруулан оруулсан төслийг хэлэлцэн шаардлагатай гэж үзсэн саналыг Засгийн газар төсөлдөө тусган дахин боловсруулах замаар эцэслэгдсэнийг батлах тухай ойлголт юм. Энэ үүднээс миний бие Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2 дахь заалтыг зөрчин Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо 250.0 сая /бүгд 19.0 тэрбум/ төгрөгийн төсөв боловсруулан, жагсаалт гаргаж, сайд нарын багцад тараан байрлуулж батлан гүйцэтгэх эрх мэдэлд халдсаныг зохион байгуулалттайгаар Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 "төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг... хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа юм.

5. Аймгийн Засаг дарга нарын уулзалт дээр "Зарим аймаг Улсын Их Хурлын гишүүдтэй ярилцсан зүйл ч байна. Ярилцаж амжаагүй ч байна. Үүнийг орон нутгийн иргэдийн хүсэн хүлээгээд байгаа зүйл рүү Засгийн газар чиглүүлсэн нь дээр байх. Улсын Их Хурлын гишүүний мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, цухалзсан байгаа юм болов уу.

Улсын Их Хурлын гишүүний санаачлага гэхээсээ аймаг, орон нутаг, Засгийн газрын хэрэгжүүлэх ажил болгон тавимаар байна. Болж өгвөл ерөнхий дүнг Улсын Их Хурал баталж өгөөд орон нутаг оновчтой ажиллах зарчмыг бүгдээрээ хөөцөлдвөл яасийм". Эндээс авч үзвэл Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид тайлбартаа "орон нутгийн саналыг харгалзан" гэж бичсэн нь чухамдаа 2000 онд Үндсэн хуульд дахин халдахдаа "ард түмний захиалга" нэрийн дор урьдчилан бэлтгэсэн "талархлын бичиг"-т "дуулгавартай" хэдэн сэхээтний гарын үсэг зуруулж, нийтлүүлж байсантай агаар нэгэн "амташсан хэрээ 13 дахины" үлгэрийг үзүүлэн яаруу, сандруу санал солилцсон дүр эсгэж, олон түмнийг төөрөлдүүлэх арга мэх гэж үзэж байна.

6. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид тайлбартаа "төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар завдах гэдэг нь уг эрх мэдлийг хууль бусаар авах зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг ойлгодог билээ. Ийм үйл ажиллагааны хэлбэр нь төрийн эрх мэдлийг авах зохион

байгуулалттай ажиллагаа хийсэн тухайлбал, бослогод бэлтгэх, олон нийтийг хамарсан самуун дэгдээх, засгийн эрх мэдлийг авах ажиллагааг удирдан зохион байгуулсан зэрэг үйл ажиллагаа байдаг" гэсэн байна.

Эдгээр нь хэлбэрийн хувьд дээрх заалтад хамаарах боловч хууль зүйн талаасаа иргэний эрх зүйн бус эрүүгийн эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэгдэх хэлбэр юм. Харин Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо 250.0 сая төгрөг хуваарилахаар санаачилга гарган шийдвэрлэсэн нь зохион байгуулалттай хийгдсэн учир "зохион байгуулалттай үйл ажиллагаа гэдэг" гэсэнтэй санал нэг байна. Миний өргөдөлд дурдсан нэхэмжлэлийн шаардлага нь Үндсэн хуулиар эрх мэдэл хуваарилан тогтоосон бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдийн зүгээс зохион байгуулалттайгаар гүйцэтгэх эрх мэдлийн улсын төсөв боловсруулан Улсын Их Хуралд өргөн хэлэлцүүлж, батлуулах эрхэнд 19.0 тэрбум төгрөгийн хязгаарт халдан, авч хэрэгжүүлсэн тухай мөн дараагийн сонгуульд давуу байдлыг урьдчилан бүрдүүлж "сонгууль /санал/ луйвардах" замаар хууль тогтоох эрх мэдлийг авахаар завдсан байж болох асуудал гэдгийг ойлгохыг хүсээгүй, ойлгосон ч "бултах" арга зам хайж, хаацайлах гэсэн тайлбар гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч хоригтоо "...дараагийн Улсын Их Хурлын сонгууль тэгш эрхийн үндсэн дээр шударга явагдах боломж алдагдах нөхцлийг урьдчилан бүрдүүлсэн" гэсэн бол хууль цаазын утга зохиолд тэмдэглэснээр "төр засагт хамаатай хамаагүй юм амлаж, өр тавьчихаад салам нэхэгддэг занганд орж... амалсандаа хүрдгээ харуулах, нөгөөтэйгүүр ирэх сонгуулийн барьцаа болгож төсвийн хэдэн төгрөгийг учир зүтгүү өрсөлдөн тарааж... сонгууль /санал/ луйвардах нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг завдах гэсэн Үндсэн хуулийн заалтад хамаатай" болохыг тодорхойлсонтой нийцэж байна.

Эндээс авч үзвэл миний өргөдөлдөө дурдсан Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэсэн нэхэмжлэлийн шаардлага хангагдах үндэстэй болохыг Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүлээн зөвшөөрчээ гэж үзэж болохоор байна.

Энэ бүхнээс миний бие өргөдөлдөө дурдсан шаардлагаудаа бүрэн үндэслэлтэй гэж үзэхийн зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт заасан Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурал үл ойлгоон

хүлээж аваагүй учир дээрх асуудлыг Үндсэн хуулийн цэцээр хянан магадлуулах нь зүйд нийцнэ гэж үзэж, энэ бүхний өргөдөл гаргахдаа дутуу дулимаг хандсанаа хүлээн зөвшөөрч доорхи шаардлагыг нэмэлт болгон гаргаж байна.

Монгол Улсын 2007 оны төсөвт Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт гишүүдийн гаргаж өгсөн жагсаалтаар 250.0 сая /бүгд 19.0 тэрбум/ төгрөгийг хөрөнгө оруулалт нэрээр "халхавчлан" салбар хариуцсан сайд нарын багцад тараан байрлуулж баталсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байгаа тул хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

НЭГ. Монгол Улсын Их Хурал "Монгол Улсын 2007 оны төсвийн тухай" хуулийн төслийг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын зарим гишүүдийн гаргасан саналын дагуу гишүүдээр жагсаалт гаргуулж Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагч нар болон шадар сайдын багцад тараан байршуулж, хөрөнгө оруулалтын жагсаалтыг хавсралтаар баталсан болох нь Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2006 оны 10 дугаар сарын 26, 27; 11 дүгээр сарын 21, 26, 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан, Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы Төсвийн байнгын хорооны 2006 оны 11 дүгээр сарын 20, 29-ны өдрийн хуралдаан, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 186 дугаар тэмдэглэлүүд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Будын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө оруулалтын саналын жагсаалт зэргээс тодорхой харагдаж байна. Тухайлбал,

1. Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэл

Уг хуралдаан дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Очирхүү хэлэхдээ: "...Орон нутагт өгч байгаа 500 саяа болье гэсэн. Сумдад 10 сая өгдөгөө хэвээр нь байлга. Харин 500 саяа Улаанбаатар хотын 20 гишүүнээ нэмээд 76 гишүүнээ бүгдийг нь оруулаад 250, 250 саяар тойрог болгонд өгье... Гэхдээ томъёоллын хувьд юу гэсэн бэ? гэхээр түүн бид нар 100 сая

дээр хориг авч байсан, шүүмжлэлд өртөж байсан учраас ерөөсөө бүс нутгийн хөгжлийн асуудалд зориулсан багцаа шадар сайд дээр хийчихээд, гишүүдтэйгээ зөвлөөд явдгаар ийм зохицуулалт хийе гэснийг манай гишүүд онцгой анхаарч хэрэгтэй. Бид нар хоригт ороод эвгүй байдалд орчих вий гэж ингэж бодож байна.

...ерөөсөө гишүүдэд, 76 хүнд 250 сая 250 саяар бодоод, тэгээд тойргийнхоо тоогоор очно биз. Тэр 250 саяынхаа хүрээнд тохирье гэсэн ийм л зүйл ярьсан..." гэжээ.

Мөн хуралдаан дээр Сангийн сайд Н.Баярсайхан хэлэхдээ: "...2006 оны төсвийн чөлөөт үлдэгдэл 100 тэрбум төгрөгийг Улсын Их Хурлаас гарч ажилласан 2 ажлын хэсгийн санал болгож байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах нь зүйтэй гэж ярьсан... Байнгын хороод дээр яригдсан саналуудыг нэг бүрчлэн шүүж үзлээ.

Ерөнхийдөө Улсын Их Хурлын гишүүдэд 250, 250 сая төгрөгөөр тооцож шадар сайдын төсвийн багцад 19 тэрбум төгрөгийг суулгаж гэж шийдсэн учраас бид аймаг руу хандсан, тусгай тойрог руу хандсан саналуудыг 250-д нь багтаах чиглэлээр ажиллахаас өөр ямар ч арга байхгүй.

...Орон нутгийн хөгжлийг дэмжихэд 10 тэрбум төгрөг байгаа, 76 гишүүнээрээ бодохоор 19 тэрбум төгрөг шаардлагатай болж байгаа. Тийм учраас нэмж 9 тэрбумыг... суулгалаа..." гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Н.Баярсайхан: "...Нийт саналуудыг нь шүүгээд үзсэн чинь 70, 80 хувь нь дандаа тойрог руу хандсан ийм саналууд байсан. Бид тэрийг шүүж үзээд Их Хурлын гишүүн болгонд 250, 250 саяаг өгье. Ер нь тэгээд тойрог руу хандсан саналуудаа татъя гэсэн зарчим дээр ажлын хэсэг дээр ярьсан..." гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн, МАХН-ын бүлгийн ахлагч Д.Идэвхтэн: "...Тэгэхээр энийгээ нэг гишүүнд дунджаар 250 сая гэж бодоод, ингэж нийгэд зарлахгүй, орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт гэж нэрлээд ...76 гишүүнд тус бүр 250 сая гэж бодоод 19 тэрбум болж байгаа юм. ...9 тэрбум төгрөгөөр орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт нэмэгдэнэ..." гээд санал хураалгаж 100 хувь дэмжигдсэн байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.

Уг хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, Төсвийн байнгын хорооны дарга Ч.Улаанаас асуухдаа: "...250 сая төгрөгийн тухайд нийгмийн санаа бодол их таагүй байгаа, энийг Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэж байхдаа анхаарч үзсэн үү... Яагаад гэвэл ноадах чинь Төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг зөрчиж орж ирээд байгаа зүйл шүү дээ. ...тэр 250 сая төгрөг чинь төсвийн ерөнхийлөн захирагч нараар дамжилгүйгээр шууд Улсын Их Хурал дээр ороод ирсэн байхгүй юу..." гэхэд Ч.Улаан: "...хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг хянаж үзээд тэгээд эцсийн шийдвэр гаргахдаа хуулиндаа нийцүүлээд эрх захирагч нэг бүрээр нь одоо ингээд заагаад объектоой, төсөлтэй нь батлаад өгчихнө гэж тогтсон юм..." гэсэн байна.

3. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2006 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

Уг хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Т.Очирхүү хэлэхдээ: "...Гишүүд одоо аймгийнхаа, бүс нутгийнхаа саналуудыг өгсөн. Зөвлөл, бүлгээрээ өгсөн байгаа. За бусад гишүүд ер нь бүх гишүүд өгчихөж байгаа. Тэгэхээр тэрнийг шадар сайдын багц дээр өмнөх жилүүдэд бичиж ирсэн. 2006 онд 7.6 тэрбум төгрөг бичээд, тэгээд тэр 7.6 тэрбум төгрөгийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нартай яриад гишүүдийн саналыг аваад ингээд зарцуулаад ирсэн.

...Одоо 19.0 тэрбум төгрөгийг 2006 он шигээ шадар сайдын багц дээр бичихгүйгээр вариант оруулж ирж байгаа. Тэр нь...төсвийн ерөнхийлөн захирагчдын багцууд дээр гишүүдийн саналыг жагсаалтаар нь оруулчихаж байгаа... (Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 32-ын 2-ын 5 дугаар заалтаар хориг таавсан юм билээ, нодчин. Яг тэр заалтын дагуу одоо бол болж байгаа..." гэжээ.

"...хөрөнгө оруулалтын жагсаалтыг гаргаж өгөөгүй гишүүд хичнээн байгаа бол?... гэсэн Ж.Батхуяг гишүүний асуултад Т.Очирхүү: "...гадаадад явж байгаа, томилолттой байгаа 7, 8 хүн байсан. Одоо тэрнээс 2, 3 хүн нь өөрсдөө утсаар саналаа өгчихөөд байгаа. 5, 6 хүн л үлдээд байгаа юм шиг байна... Тэд нарын багцдйг /250 сая төгрөгийг/ аймагаар нь... шадар сайдын багц дээр хийчихээд 2006 ондоо 7.6 тэрбумлаа ашигласан тэрүүгээрээ явчихъя л гэсэн тийм санаа л оруулж ирж байгаа..." гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ч.Улаан хэлэхдээ: "...250 саяыг тойрсон асуудлууд яригдаад ажлын хэсэг төсвийн эрх захирагчдад нь төсөв рүү хийж өгье гэж танилцууллаа шүү дээ. ...Төсвийн 4 дүгээр хэлэлцүүлгийн явцад төсвийг эрх захирагч нэг бүрээр баталдаг. Тэгэхээр тэр төсөв дотор нь одоо эрх захирагч болгонд суулгаж өгнө. ...дөрөвдүгээр хэлэлцүүлгийн өмнө хэн хэний төсөв дээр хичнээн юм яаж тусав гэдгийг бид нар сонсоод дөрөвдүгээр хэлэлцүүлэгт орох бололцоотой... гэсэн байна.

4. 2007 онд Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнөө оруулалтын талаар гаргасан зарим гишүүдийн санал, жагсаалт.

Үндсэн хуулийн цэцээс шаардсаны дагуу Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай, Ц.Жаргал, С.Оюун, М.Зоригт нар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд гаргасан хөрөнгө оруулалтын санал, жагсаалтаа ирүүлсэн ба МАХН-ын бүлэг, ардчилсан намын зөвлөл гишүүдийнхээ гаргасан санал, жагсаалтыг удаа дараа шаардсаар байхад Үндсэн хуулийн цэцэд ирүүлээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ. Дээрхи нэр бүхий гишүүдийн гаргасан санал, хөрөнгө оруулалтын жагсаалт нь "Монгол Улсын 2007 оны төсвийн тухай" хуулийн арван нэгдүгээр зүйлийн нэгдүгээр хавсралтын ХҮИ.1.39, ХҮ1.1.72, ХҮИ.1.16, ХҮ1.2.3.9, ХҮ1.1.1.76, IX.2.7, XXIII.1.42, ХҮ1.1.2.4, ХҮ1.1.2.51, ХҮ1.1.2.5, ХҮ1.2.1.15, ХҮ1.1.2.6, ХҮИ.4.6, XXIII.1.42, ХҮ1.1.2.7, IX.2.8, ХҮ1.2.1.16, ХҮ1.1.2.8, X.1.3.2, XXIII.1.18, IX.1.5, ХҮ1.2.1.21, ХҮ1.1.2.1.8-д бүрэн тусгагдсан, Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн даргын 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 26 тоот албан бичигт: "...Улсын Их Хурлын гишүүд нь өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд улсын төсөвт дээр дурдагдсан хөрөнгө оруулалтын талаар Улсын Их хурлын холбогдох байнгын хороогоор дамжуулан асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэж байна..." гэсэн зэргээс харахад санал, жагсаалт өгсөн бусад гишүүдийн хөрөнгө оруулалтын санал ч дээрх жагсаалтад, санал өгөөгүй цөөн гишүүдэд хуваарилагдсан 250 сая төгрөг нь шадар сайдын багцад нийт дүнгээрээ 750 сая төгрөг гэж тусгагдсан гэх үндэстэй байна.

Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-т зааснаар: "...2/... улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; ...бүрэн эрхийг

хэрэгжүүлэх ба "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар "...Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төслийг боловсруулах, "... бүрэн эрхтэй юм.

Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан "Монгол Улсын 2007 оны төсвийн төсөл"-д Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийн хөрөнгө төсөвлөгдөөгүй байхад Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэх явцадаа Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд халдаж төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2007 оны төсвийн багцгийг сонгуулийн тойрог харгалзан нэмэгдүүлж, Улсын Их Хурлын гишүүдийн саналыг хөрөнгө оруулалтын жагсаалтаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад тараан байрлуулсан баталсан байх ба ингэхдээ ижил төрлийн хөрөнгө оруулалтын объектод санхүүжилтийн дүнг өөр өөрөөр тусгасан, нэг үйл ажиллагааны санхүүжилтийг 2 дахин давхардуулан тусгасан, төрийн санхүүгийн бодлогын хүрээнд шийдвэрлэгдэхээргүй асуудлыг төсвийн хуулийн хавсралтаар баталсан зэргээс үзэхэд Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг механикаар төсөвт суулгасан болох нь "Монгол Улсын 2007 оны төсвийн тухай" хуулийн Арван нэгдүгээр зүйлийн нэгдүгээр хавсралтын IX.1.10, IX.1.11, IX.1.28, IX.1.4, IX.1.24, ХҮЛ.2.1.15, ХХҮИИ.1.16 зэргээр тогтоогогдож байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2/, Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

ХОЁР. Мэдээлэл гаргагч иргэн Н.Хайдав Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт заасан Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурал үл ойлгоон хүлээн аваагүй учир дээрх асуудлыг Үндсэн хуулийн цэцээр хянуулахаар мэдээллийн нэмэлт шаардлага болгон ирүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2006 оны 12 дугаар сарын 18-нд Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд тавьсан хоригтоо:

1. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан зөвхөн сонгууль явуулахын тулд зохион байгуулагддаг сонгуулийн нутаг дэвсгэрийг баримтлан хөрөнгө оруулахаар төсөвлөсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Аймаг, нийслэл,

сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цолцолбор мөн" гэсэн заалтыг зөрчиж төсвийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг баримтлан зарцуулах зарчмыг алдагдуулсан.

2. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн ажиллагаан: үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчиж дараагийн Улсын Их Хурлын сонгууль тэгш эрхийн үндсэн дээр шударга явагдах боломж алдагдах нөхцлийг урьдчилан бүрдүүлсэн.

3. Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний эгч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаална" гэсэн заалтыг зөрчиж "сонгуулийн нутаг дэвсгэрийг" явцуу эрх ашгийг хичээж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн онцлог нөхцөл байдлыг үл харгалзан тэгшитгэн хуваарилах зарчмаар нэмэлт хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна гэж үзжээ.

Эл асуудлаар Улсын Их Хурлын зарим гишүүд өөрийн үзэл бодлоо илэрхийлж байсан нь дараахь баримтаар нотлогдож байна. Үүнд

1. Монгол Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.

Уг хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл хэлэхдээ: "...их ноцтой асуудал яваа шүү дээ. ... Энэ чинь яг үнэндээ Т.Очирхүү гишүүний хэлж байгаагаар бол энд сууж байгаа 76 гишүүний тойрог дээр хөрөнгө оруулалт хийх, цаад утгаараа бол 2008 оны сонгуульд хийж байгаа хөрөнгө оруулалт байгаа байхгүй юу. Улс төрийн хөрөнгө оруулалт шүү дээ. ... Энэний цаана чинь... ардчилсан сонгууль, чөлөөт ардчилсан сонгууль гэдэг чинь устаж байгаа гэдгийг бид нар мэдэж байгаа шүү дээ. Одоо удахгүй 500 сая болно. Удахгүй 1 тэрбум болно. ...Одоо жишээ нь надтай 2008 онд хэн үзэлцэх юм..." гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаяр хэлэхдээ: "...хамгийн гол зарчим нь бол их олон хууль, их олон зарчим алдагдаж байгаа юм л даа. ...Их олон хуулинд нөгөө сонгуульд нэр дэвшигчид бол эрх тэгш, нэг гараанаас илэр хэмжээтэйгээр өрсөлдөнө гэсэн зарчим маань алдагдахад хүрнэ гэж би үзэж байгаа

юм... Хоёрдугаарт, ... одоо гадуур та нар өнөөдрийн сонин хэвлэлийг үзсэн байх. ... Өөрсөддөө зориулж мөнгө баталж авдаг Улсын Их Хурал гээд шуугиад байна шүү дээ. ... Энэ арай дэндүү байгаа байхгүй юу. Хичнээн тайлбарлаад ч энэ чинь ямар ч тайлбар хэрэггүй ээ гэдгийг хэлмээр байна..." гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай "Тэгэхээр 250 сая төгрөгийн саналыг бол Ард түмний нэм дэмжихгүй байгаа. ... Яагаад 250 саяыг бид эсэргүүцээд байгаа юм бэ гэхээр энэ бол ерөөсөө... Их Хурлын гишүүдэд өгч байгаа хахууль шүү дээ..."

...Улсын Их Хурлын гишүүд гэдэг чинь хөрөнгө мөнгийг төсөвлөж баталдаг хүмүүс болохоос биш энэнийг зарцуулдаг этгээд биш ээ. Их Хурлын гишүүд өнөөдөр тойрог дээрээ очоод тэр 250 сая төгрөгийг нааш нь цааш нь хийснээрээ ажил хийсэн болохгүй ээ. Их Хурлын гишүүн ард түмэнтэйгээ уулзаж ярьж тэдний санаа сэтгэлийг ойлгож тэдний хэрэгтэй тэр хуулийн төслийг эрх зүйлн орчинг нь бүрдүүлж Монгол Улсын парламентад батлуулахыг л ажлаа хийсэн гэдэг юм. Засгийн газраа хянаж ажиллахыг ажлаа хийсэн гэдэг юм. ...Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд та нар энэ зүйл дээрээ татгалзамаар байна..." гэжээ.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д: "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэж заасан.

Гэтэл Улсын Их Хурлын гишүүд зөвхөн өөрийн сонгогдсон Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн явцуу эрх ашгийн үүднээс сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх жагсаалт гарган хөрөнгө оруулалтын санхүүжилтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зарчмаар бус, Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн зарчмаар хуваарилан тэгшитгэж, түүнийгээ халхавчлан төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад суулган хуульчлан баталсан, ингэснээрээ Улсын Их Хурлын сонгуульд оролцох намууд болон нэр дэвшигчдэд тэгш бусаар өрсөлдөх нөхцлийг бий болгосон, төсвийн ерөнхийлөн захирагч нар Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан тэдэнтэй зөвшилцөж хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийхээр болсон, мөн "Монгол Улсын 2007 оны төсвийн тухай" Монгол Улсын хуулинд Улсын Их Хурлын 76 гишүүний тойрог тус бүрт 250.0 сая

төгрөгөөр тооцож нийт 19.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах шатанд энэ талаар хуулиар тогтоосон журмыг Улсын Их Хурал хэрэгжүүлээгүй эзрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2/, Тавин наймдугаар зүйлийн 1, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Улсын Их Хурлын гишүүдийн зөвхөн хувь хувийн бодлоор хөрөнгө оруулалтын санал өгөгдсөн түл ижил объектуудыг барихад зарцуулах зардлын хооронд ялгаа их гарч шудрага ёс, тэгш байдлын зарчим зөрчигдөхөд хүрсэн байна. Үүнийг зөвхөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дээрх жишээгээр авч үзэхэд тухайлбал, багийн Засаг даргын конторын барилгыг Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр багт барихад 20.0 сая, Сэлэнгэ аймгийн Шаамарт барихад 50.0 сая, Төв аймгийн Бүрэн суманд барихад 70.0 сая төгрөг төсөвлөгдсөн байна.

Мөн сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг Өвөрхангай аймгийн Уянга суманд барихад 250.0 сая, Сүхбаатар аймгийн Уул-баян суманд барихад 25.0 сая төгрөг зарцуулах зэргээр төсөвт тусгагджээ.

Аймаг, нийслэлийн Засаг даргын багцад зарим гишүүд сонгогчдынхоо /иргэдийн/ хувьчлагдсан орон сууцны байрны засварыг төсвийн хөрөнгөөр засуулахаар төсөвлөсөн байна. Тухайлбал, Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт.

Мөн зарим сайдын эрхлэх ажлын хүрээнд үл хамаарах ажлыг Улсын Их Хурлын гишүүдийн саналаар хүчээр байршуулсан байна. Тухайлбал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад Булган, Чойбалсан, Өвөрхангай, Арвайхээрийн гэрэлтүүлэг, Ховд, Жаргалантын гэр хорооллын автобусны зогсоол зэрэг асуудлууд тусгагдсан нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх хэмжээнд халдсан шинжийг тус тус агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон